



Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

Тараах: Ерөнхий
2020 оны 9 дүгээр сарын 17

Эх хувь: Англи хэл дээр

Албан бус орчуулга

Хүний Эрхийн Хороо

Тайван хуран цуглах эрхийн (21 дүгээр зүйл) талаарх Ерөнхий тайлбар No. 37 (2020)

I. Танилцуулга

1. Хүний тайван хуран цуглах үндсэн эрх нь хувь хүмүүст үзэл бодлоо хамтдаа илэрхийлэх, нийгмээ төлөвшүүлэхэд оролцох боломжийг олгодог. Тайван хуран цуглах эрх нь хувь хүмүүсийн бусадтай эв санааны үндсэн дээр зөвшилцөж, өөрсдийн засаглах эрх чөлөөг эдлэх чадварыг хамгаалдаг тул нэн чухал эрх юм. Бусад холбогдох эрхүүдийн хамт, энэхүү эрх нь ардчилал, хүний эрх, эрх зүйт ёс, олон ургалч үзэлд суурилсан оролцоот засаглалын тогтолцооны үндсэн суурийг бүрдүүлдэг. Тайван хуран цуглах нь олон нийтийн дунд үзэл санаа, хүсэл эрмэлзлэл, зорилгоо өргөн тавих, дэвшүүлэх, илэрхийлэх боломжийг оролцогчдод олгох, тэдгээр үзэл бодол, зорилгоо дэмжсэн эсхүл эсэргүүцсэн, үл дэмжсэн цар хүрээг бий болгоход чухал үүрэг үзүүлж чадна. Тэдгээр нь гомдол гаргахад ашиглагдвал тайван цуглаан нь бүхнийг хамарсан, оролцоонд тулгуурласан, тайван аргаар өөр хоорондоо ялгаатай байдлуудыг шийдвэрдэх боломжуудыг бий болгох боломжтой.
2. Түүнчлэн, тайван хуран цуглах эрх нь эдийн засгийн, нийгмийн, соёлын гэх мэт олон төрлийн эрхийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэхэд ашиглагдаж буй, мөн ашиглагдаж болохуйц үнэ цэнтэй хэрэгсэл юм. Энэ нь гадуурхагдсан, нийгмээс тусгаарлагдсан хүмүүс, бүлгүүдэд онцгой ач холбогдолтой. Тайван хуран цуглах эрхийг үл хүндэтгэх эсхүл үл хангах нь хүч хэрэглэж буйн нэгэн нийтлэг шинж тэмдэг юм.
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлийн эхний өгүүлбэрт заасанчлан, “Тайван хуран цуглах эрх нь хүлээн зөвшөөрөгдөх нь зүйтэй”. Тус эрхийг олон улсын болон бүс нутгийн бичиг баримтуудад ижил төстэй байдлаар томъёолсон бөгөөд түүний агуулга нь хянах байгууллагуудын үзэл бодол, ажиглалт, тогтоол, тайлбар удирдамж, шүүхийн шийдвэр зэрэгт үндэслэн баяжигдсан болно. Олон улсын хууль тогтоомжийн дагуу тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрөх үүрэгтэйгээс гадна, ихэнх улс орнууд өөрсдийн үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрсөн байдаг.
4. Тайван хуран цуглах нь хүмүүсийн тодорхой зорилготойгоор, нэн тэргүүнд өөрсдийнхөө санал бодлыг илэрхийлэх зорилготой, хүчирхийлэл үгүй цуглааныг хамгаалдаг. Энэ нь хувь хүмүүсийн өөрсдийн үзэл бодлоо хамтын замаар илэрхийлэх эрхээ эдлэхийг баталгаажуулдаг. Тиймээс энэхүү эрхийн салшгүй нэгэн хэсэг бол нийтэч байдал юм.

5. Хүн бүр, иргэн ч, иргэн бус харьяат ч, нэгэн адил тайван хуран цуглах эсвэл жагсаал хийх эрхтэй. Энэхүү эрхийг түүнчлэн гадаадын иргэд, цагаачлагчид баримт бичигтэй, баримт бичиггүй, орогнол хүсэгчид, дүрвэгсэд, улс орны харьяалалгүй хүмүүс ч эдэлж болно.
6. Пактын 21 дүгээр зүйл нь гадна талбайд, дотор орчинд болон цахимд, эсхүл олон нийтийн болон хувийн орон зайд, эсхүл хосолсон гэх мэт бүх төрлийн тайван цуглааныг хамгаалдаг. Ийм цуглаан нь жагсаал, эсэргүүцэл, цуглаан, суулт, лаа асаалт, флаш моб гэх зэрэг олон хэлбэртэй байж болно. Тэдгээр нь эсэргүүцэл, жагсаал гэх мэт идэвхтэй, эсхүл суулт гэх мэт идэвхгүй хэлбэрт байхаас үл шалгаалан 21 дүгээр зүйл ангиар хамгаалагдсан болно.
7. Ихэнх тохиолдолд, тайван цуглаан нь ярвигтай, маргаантай зорилгуудыг урьтал болгодоггүй бөгөөд ямар нэг саад тотгор учруулдаггүй, эсхүл бага зэрэг учруулдаг. Тэдгээрийн зорилго нь, тухайлбал үндэснийхээ өдрийг, эсхүл спортын арга хэмжээний үр дүнг тэмдэглэх байж болно. Гэсэн хэдий ч, тайван цуглааныг зарим тохиолдолд маргаантай санал санаачилга, маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглаж болно. Тэдгээрийн цар хүрээ, мөн чанар нь тээврийн хэрэгслийн болон явган хүмүүсийн үймээн, эсхүл эдийн засгийн үйл ажиллагаа гэх мэт олныг хамарсан, эмх замбараагүй байдал үүсгэж болно. Төлөвлөгдсөн болон үл төлөвлөгдснөөс үл хамааран, эдгээр үр дагавар нь тайван хуран цуглахад хамгаалуулах эрхээ эдлэхэд нь саад тотгор учруулдаггүй. Аливаа үйл явдал дээрх эмх замбараагүй байдал, эсхүл эрсдлийг бий болгож болзошгүйг харгалзан үзэж, үүнийг Пактын хүрээнд зохицуулах ёстой.
8. Тайван хурах цуглах эрхийг хүлээн зөвшөөрөх нь оролцогч улсуудад тайван цуглаанд хүндэтгэл үзүүлэх, тэдгээр нь ялгаваран гадуурхалд өртөлгүйгээр энэхүү эрхийг эдлэхэд нь хяналт тавих үүрэг хүлээлгэдэг. Энэ нь үндэслэл үгүй, хөндлөнгөөс оролцохгүйгээр жагсаал цуглааныг үйл ажиллагаагаа явуулах, эрхээ эдлэх, оролцогчдоо хамгаалах нөхцлүүдийг бүрдүүлэхийг улсуудаас шаарддаг. 21 дүгээр зүйлийн хоёр дахь өгүүлбэр нь болзошгүй хязгаарлалтын үндэслэлүүдийг зааж өгсөн боловч ийм хязгаарлалтууд нь нарийн тодорхойлогдсон байх ёстой. Эдгээр нь хязгаарлаж болох хязгаарлалтуудын хязгаар болох юм.
9. Тайван хуран цуглах эрхийг гагцхүү давхцаж байгаа бусад эрх, ялангуяа, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх эрх чөлөө, улс төрийн оролцооны зэрэг эрхүүд хангагдсан, хамгаалагдсан үед бүрэн хамгаалах боломжтой. Тайван хуран цуглах эрхийг хамгаалах нь ихэвчлэн, иргэний болон улс төрийн эрхийг илүүтэйгээр, мөн эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг хэрэгжүүлэхээс тус бүр хамаардаг. Хувь хүний зан үйлдэл нь тэднийг 21 дүгээр зүйлийн хамгаалалтын хүрээнээс гадна байрлуулсан тохиолдолд буюу, жишээлбэл, зохисгүй, хүчирхийллийн зан авир гаргасан тохиолдолд, хувь хүмүүс Пактад заасанчлан өөрсдийн бусад эрхээ эдлэх боловч тэдгээр нь холбогдох хязгаарлалт, эрх хязгаарлалтаас үл зайлна.
10. Цуглаан зохион байгуулах арга зам, тэдгээрийн нөхцөл байдал нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг. Энэ нь эрх баригчдын тэдэнд хариу арга хэмжээ авахад нөлөөлж магад. Тухайлбал, шинээр гарч ирж буй харилцаа холбооны дэвшилтэт технологи нь бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн цахимаар цуглаан хийх боломжийг олгохын зэрэгцээ нүүр тулсан цуглааныг зохион байгуулах, оролцох, хянахад салшгүй үүрэг гүйцэтгэдэг тул ийм харилцаанд хөндлөнгөөс оролцох нь тайвнаар хуран цуглахад саад тотгор учруулж болзошгүй. Тандалтын технологийг хүчирхийллийн аюул заналхийллийг олж илрүүлэх, улмаар олон нийтийг хамгаалах зорилгоор ашиглаж болох хэдий ч, энэ нь оролцогчид болон хөндлөнгийн ажиглагчдын хувийн нууцыг хамгаалах эрх болон бусад эрхийг зөрчихийн сацуу үг хэлэх эрх чөлөөг доройтуулах эрсдэлтэй. Түүнчлэн, нийтийн эзэмшлийн орон зай, харилцаа холбооны платформуудад хувийн өмчлөл болон хяналтын бусад хэлбэрүүд их бий. Эдгээрийг анхааран үзэх нь,

21 дүгээр зүйлд шаардсанчлан, хууль эрх зүйн орчны талаарх орчин үеийн ойлголтыг өөртөө багтаах нь нэн шаардлагатай.

II. Тайван хуран цуглах эрхийн хамрах хүрээ

11. 21 дүгээр зүйлд заасны дагуу хэн нэгний цуглаанд оролцох эрхийг хамгаалж байгаа эсэхийг тогтоох нь хоёр үе шаттай явагдана. Нэгдүгээрт, тухайн хүний зан байдал нь санал болгож буй хамгаалах эрхийн хүрээнд багтаж байгааг эсэхийг тогтоох ёстой ба энэ нь “тайван хуран цуглах”-д оролцоход хамаарагддаг учиртай. Хэрэв тийм бол, дараах гуравдугаар хэсэгт тодорхойлсончлон тухайн улс оролцогчдын эрхийг хүндэтгэж, тэдний эрхийг хангах ёстой. Хоёрдугаарт, эрхээ эдлэхэд буюу хэрэгжүүлэхэд саад болж буй хязгаарлалт нь тухайн нөхцөл байдалд хуулийн хүрээнд байгаа эсэхийг тогтоох ёстой (доорх дөрөвдүгээр хэсэгт тайлбарласанчлан).

12. “Цуглаан”-д оролцох гэдэг нь өөрийн санал бодлоо илэрхийлэх, тодорхой асуудлаар өөрийн байр сууриа илэрхийлэх, бусадтай санал бодлоо солилцох зорилгоор хуран цуглаж буй хүмүүсийн цуглааныг зохион байгуулах, эсхүл түүнд оролцохыг хэлнэ. Энэхүү цуглаан нь түүнчлэн бүлгийн эв санааны нэгдэл эсхүл онцлог шинж чанараа батлах, зарлах зорилготой байж болно. Цуглаан нь ийм зорилго тавихаас гадна зугаа цэнгэл, соёл урлаг, шашин шүтлэг, арилжааны зэрэг бусад зорилгод үйлчилж болох бөгөөд 21 дүгээр зүйлд зааснаар хамгаалагдсан хэвээр байх болно.

13. Цуглаан хэмээх ойлголт нь цуглаанд нэгээс илүү оролцогч байх болно гэсэн санааг илэрхийлдэг бол 19 дүгээр зүйлд заасны дагуу аливаа ганц эсэргүүцэгч нь энэхүү Пактын дагуу эн тэнцүү хамгаалалтуудыг эдэлдэг. Тухайлбал, тайван хуран цуглах эрхээ эдлэх, хэрэгжүүлэх нь нүүр тулсан буюу биет цуглааны үрээнд ойлгогддог хэдий ч 21 дүгээр зүйлийн хамгаалалт нь алсаас буюу цахим цуглаанд оролцох, түүнийг зохион байгуулахыг мөн хамааруулдаг.

14. Тайван цуглаанд ихэвчлэн урьдчилан зохион байгуулдаг бөгөөд шаардлагатай бэлтгэл ажлыг нь хангуулахын тулд эрх баригчдад мэдэгдэх зэрэг цаг хугацааг зохион байгуулагчдад олгодог. Гэсэн хэдий ч, зохицуулалттай эсэхээс үл хамааран, тухайн цаг үеийн хариу үйлдэл болон зохион байгуулагдсан албадлагын бус цуглаанууд нь 21 дүгээр зүйлд заасны дагуу эн тэнцүү хамгаалагдсан байдаг. Нэг цуглаан нь нөгөөгөө эсэргүүцэж байгаагаа илэрхийлж буй үед сөрөг жагсаал тохиодог. Тухайн хоёр цуглаан хоёул 21 дүгээр зүйлийн хамгаалалтын хүрээнд багтаж болно.

15. “Тайван” цуглаанд нь өргөн цар хүрээг хамарсан ноцтой хүчирхийллийн шинжтэй цуглаантай зөрчилддөг. Ийм учраас, “тайван” ба “хүчирхийллийн бус” “хүчирхийлэлгүй” гэсэн нэр томъёонууд нь нэг ижил утга санаагаар ашиглагддаг. Тайван цуглах эрхийг, тодорхойлсончлон, хүчирхийлэл ашиглан хэрэгжүүлэхгүй байх нь зүйтэй. 21 дүгээр зүйлийн хүрээнд, “хүчирхийлэл” гэдэг нь оролцогчид бусдын эсрэг бие махбодын хүч хэрэглэх, энэ нь гэмтэл, нас барах, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдлыг хамруулдаг. Жирийн түлхэлцээн, өөр хоорондоо шахцалдах, эсхүл тээврийн хэрэгслийн болон хүмүүсийн хөдөлгөөн, мөн өдөр тутмын үйл ажиллагаа нь энэхүү “хүчирхийлэл”-д үл тооцогдоно.

16. Хэрэв цуглаанд оролцогчдын биеэ авч явах байдал тайван бол зохион байгуулагчдын, эсхүл оролцогчдын хувьд аливаа цуглаанд хамааралтай тухайн дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй ч, энэ нь оролцогчдыг 21 дүгээр зүйлд заасан хамгаалах хүрээнээс гадуур байрлуулдаггүй. Хэрэв иргэд хүчирхийллийн бус замаар нэгдсэн бол тэдний хамтын дуулгаваргүй байдал, эсхүл үйл ажиллагаагаа явуулж буй кампанит ажлууд нь 21 дүгээр зүйл ангид хамаарна.

17. Тайван ба тайван бус цуглааны хооронд тодорхой зааг огт байддаггүй ч цуглааныг тайван гэж авч үзэх үндэслэл бий. Түүнчлэн, үйлдсэн хүчирхийллийн улмаас тугаарлагдсан зарим оролцогчдыг

бусдад, зохион байгуулагчдад эсхүл тухайн цуглаанд хамааруулахгүй байх нь зүйтэй. Иймд, цуглаанд оролцогчдын заримыг 21 дүгээр зүйлд хамааруулж болох бол бусдыг нь хамааруулахгүй байж болно.

18. Цуглаан нь тайван эсэх асуулт нь оролцогчдын зүгээс үүсгэсэн хүчирхийлэлтэй холбоотойгоор хариулагдах ёстой. Тайван цуглаанд оролцож буй оролцогчдын эсрэг эрх баригчдын эсхүл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулдаг өдөөн хатгагч нарын хийсэн хүчирхийллийг тухайн цуглаанд хамааруулан тайван бус гэж тооцохгүй байх. Үүний нэгэн адил, тухайн цуглаанд тусгайлан чиглэсэн, олон нийтийн гишүүд, эсхүл сөрөг жагсаалд оролцож буй оролцогчдын зүгээс үзүүлсэн хүчирхийлэлд ч мөн хамаарна.

19. Хэрэв тухайн үйл явдлын үеэр эсхүл өмнө оролцогчид бусдыг хүчирхийлэлд уриалж буй, хүчирхийлэл ашиглахыг уриалж буй, тэдгээр үйлдэл нь хүчирхийлэл тарьж болох эрсдэлтэй, магадлалтай бол, тухайн оролцогчид хүчирхийлэл үйлдэх санаа сэдэл агуулсан, тэднийгээ хэрэгжүүлсэн бол, эсхүл, тэдний зүгээс хүчирхийлэл айсуу болохыг эрх баригчид баримт нотолгоогоор харуулж чадвал цуглаанд оролцогчдын зарим гишүүдийн зан байдлыг хүчирхийлэл гэж үзэж болно. Ийм зан үйлдлийн улмаас тусгаарлах нь бүхэл бүтэн цуглааныг тайван бус гэж нэрлэхэд хангалтгүй ч, хэрэв энэ нь цуглааны хүрээнд илт өргөн тархсан тохиолдолд, уг цуглаанд оролцсон оролцоо нь 21 дүгээр зүйлд заасанчлан хамгаалагдахгүй болно.

20. Оролцогчдын биедээ авч явж буй зэвсэг, эсхүл хамгаалалтын хэрэгсэлд тооцогдож болохуйц хийн маск, малгай гэх мэт материаллаг зүйлс нь тэднийг хүчирхийллийн зан үйлдэлтэй гэж үзэхэд хангалтгүй. Энэ нь нөхцөл байдалд тулгуурласан, тэр дундаа, бусад зүйлсийг тухайлбал, зэвсэг (ялангуяа галт зэвсэг) биедээ авч явах дотоодын хууль, дүрэм журам, тухайн орон нутгийн соёл, тэнд хүчирхийллийн сэдэл байсан эсэхийг нотлох баримт байгаа эсэх болон тэдгээр зүйлсийг биедээ байлгаснаар, авч явснаар гарч болох хүчирхийллийн эрсдэл зэргийг харгалзан үзэх ёстой.

III. Тайван хуран цуглах эрхийн талаарх улс орнуудын хүлээх үүрэг

21. Пакт нь Пактын бүх эрхийг “хүндэтгэх, хангах” үүргийг оролцогч улсуудад хүлээлгэдэг (2 дугаар зүйлийн 1); энэ зорилгод хүрэх хууль эрх зүйн болон бусад арга хэмжээг авах (2 дугаар зүйлийн 2); хариуцлага хүлээлгэх, гэрээний эрх зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй арга хэмжээ авах (2 дугаар зүйлийн 3). Тайван цуглах эрхийг хэрэгжүүлэгч улсуудын хүлээж буй үүрэгт энэ мэт олон төрлийн элемент багтсан бөгөөд тэдний үүрэг нь зарим тохиолдолд 21 дүгээр зүйлд заасан шалгуурын дагуу хязгаарлагдаж болно.

22. Улс орнууд цуглаануудад өөрсдийн хуран цуглах зорилго, хуран цугласныхаа илэрхийлэл болсон агуулгыг чөлөөтэйгээр тодорхойлохыг оролцогчдод үлдээх ёстой. Эрх баригчдын тайван цуглаанд хандах хандлага, тэдэнд тавих аливаа хязгаарлалт нь зарчмын хувьд төвийн сахисан байхын сацуу оролцогчдын хэн болох, тэдний эрх баригчидтай холбоотой харилцаа холбоонд үндэслэхгүй байх ёстой. Түүнчлэн, цуглааны мөн чанар, байршил, цаг хугацаа нь зарим тохиолдолд 21 дүгээр зүйлд заасны дагуу хууль ёсны хязгаарлалтын үндэс болож болох ч, уг цуглааны илэрхий шинэ чанарыг харгалзан үзсэнээр, аль болох боломжийн хэрээр зорилтот бүлгийнхээ хараа, сонорын хүрээнд цуглааныг явуулах боломжийг оролцогчдод хангасан байх ёстой.

23. Тайван цуглааныг хүндэтгэх, хангах үүрэг нь цуглааны үеэр, цуглаанаас өмнө болон дараах үед, улсуудад эерэг болоод сөрөг үүргүүдийг хүлээлгэдэг. Сөрөг үүрэг нь тайван цуглаанд үндэслэлгүйгээр хөндлөнгөөс оролцохгүй байхыг шаарддаг. Тухайлбал, улсууд нь баттай нотолгоогүйгээр тайван цуглаануудыг хориглох, тараах, үйл ажиллагааг нь тасалдуудах, эсхүл хууль ёсны шалтгаангүйгээр оролцогч, зохион байгуулагчдад хариуцлага хүлээлгэхгүй байх үүрэгтэй.

24. Үүнээс гадна, оролцогч улсууд нь тайван цуглаан зохион байгуулах, оролцогчдын зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлэхэд тодорхой эерэг үүрэг хүлээдэг. Тиймд ялгаварлан гадуурхагдалгүйгээр тайван хуран цуглах эрхээ эдлэх таатай орчинг дэмжих, уг эрхийг үр дүнтэй эдлүүлэх хууль эрх зүйн болон байгууллагын буюу институцын орчинг бүрдүүлэх ёстой. Заримдаа эрх бүхий байгууллагууд тодорхой арга хэмжээ авах шаардлагатай болдог. Жишээлбэл, гудамжуудыг хаах, замын хөдөлгөөнийг дахин чиглүүлэх, эсвэл аюулгүй байдлыг хангах шаардлагатай байж магадгүй. Шаардлагатай тохиолдолд, улсууд тухайн улсын иргэн бус оролцогчдын, эсхүл олон нийтийн гишүүд, эсэргүүцэгчид, хувийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс үзүүлэх хөндлөнгийн оролцоо, хүчирхийллээс оролцогчдыг хамгаалах ёстой

25. Улсууд нь хууль тогтоомж, тэдгээрийн тайлбар, хэрэглээ нь тайван хуран цуглах эрхээ эдлэхэд арьс өнгө, үндэс угсаа, нас, хүйс, хэл, эд хөрөнгө, шашин шүтлэг, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, төрөлт, нийгмийн цөөнх, уугуул болон бусад байдал, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг хандлага, жендер, бусад байдал зэргээр үл ялгаварлан гадуурхагдахгүй байх нөхцөл байдлыг хангах ёстой. Ялгаварлан гадуурхагдаж байгаа, гадуурхагдаж болохуйц, эсхүл цуглаанд оролцоход тодорхой бэрхшээл тулгарч болзошгүй бүлгийн гишүүдэд багтдаг хүмүүсийн тайван замаар цуглах эрхийг тэгш, үр дүнтэй чиглүүлэх, хамгаалахад онцгой хүчин чармайлт гаргах ёстой. Түүнчлэн, улс орнууд оролцогчдыг бүх төрлийн ялгаварлан гадуурхал, халдлагад өртөхөөс хамгаалах үүрэгтэй.

26. Тайван цуглах эрх нь оролцогчдыг нийгмийн бусад гишүүдэд тулгарч буй бэрхшээлээс ангижруулахгүй. Улсууд эсэргүүцлийн жагсаалыг тэдний үндсэн эрхийнх нь хувьд хүндэтгэн үзэх ёстой бөгөөд тэдний эсэргүүцэж буй цуглааныг зүй зохисгүйгээр тасалдуулахаас урьдчилан сэргийлэх ёстой. Улсууд, зарчмын хувьд, эсэргүүцлийн жагсаалын агуулгынх нь хувьд төвийг сахисан байр сууриар хандах төдийгүй тэдгээр эсрэг жагсаалыг өөрсдийнхөө хараа, сонор дор зохион байгуулах боломжоор хангах ёстой.

27. Тайван хуран цуглах нь олон нийтийн дундаас зарим гишүүдийн сөрөг, тэр ч байтугай, хүч хэрэглэсэн хариу үйлдлүүдийг өдөөж болзошгүй ч энэ нь уг цуглааныг хориглох, хязгаарлах хангалттай үндэслэл биш юм. Улс орнууд нь бүх оролцогчдыг хамгаалах, мөн ийм цуглааныг тасралтгүй явуулах боломжийг олгохын тулд цуглаанд харилцан адилгүй дарамт үүсгэхгүй байхад шаардлагатай бүх боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй (мөн доорхи 52-р хэсгийг үзнэ үү).

28. Ажиллаж буй, ил тод хууль эрх зүй, шийдвэр гаргах тогтолцоо нь тайван хуран цуглах эрхийг хүндэтгэх, хангах үүргийн гол цөм нь. Дотоодын хууль тогтоомж нь тайван цуглах эрхийг хүлээн зөвшөөрөх, оролцогч бүх төрийн албан тушаалтны үүрэг, хариуцлагыг тодорхой заах, олон улсын холбогдох хэм хэмжээнд нийцсэн байхын зэрэгцээ олон нийтэд хүртээмжтэй байх ёстой. Улсууд хууль, холбогдох журмын талаар олон нийтийн мэдлэг, түүний дотор эрхээ хэрэгжүүлэх, эдлэхийг хүссэн хүмүүсийн дагаж мөрдөх журам, хариуцах харьяа байгууллагуудын эрх баригчид хэн болох, тэдгээр албан тушаалтанд хамааралтай дүрэм журам болон эрхийг зөрчсөн байж болзошгүй тохиолдолд авах арга хэмжээний талаарх олон нийтийг мэдээлэлжүүлэхэд анхаарах ёстой.

29. Оролцогч улсууд, хуран цуглахаас өмнө ба дараа, хуран цуглаж байх үед тэдний эрхийг хангахын тулд, үр дүнтэй аргаар тухайлбайл, шүүх хуралдааны арга хэмжээ, эсхүл хүний эрхийн үндэсний байгууллагуудад цаг тухайд нь нэвтрэх замаар, тайван цуглаанд оролцогч бүх байгууллагуудын бие даасан, ил тод байдлын хяналтыг хангах ёстой.

30. Сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчид, сонгуулийн мониторингууд болон цуглаанд хяналт тавих, мэдээлэх ажилд оролцогч хүмүүсийн үүрэг нь тайван хуран цуглах эрхийг бүрэн эдлэхэд

онцгой ач холбогдолтой. Эдгээр хүмүүс нь Пактын дагуу хамгаалагдах эрхтэй. Тэдний хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой гэх мэт чиг үүргүүдээ хэрэгжүүлэхэд нь хориглож, эсхүл хууль бусаар хязгаарлаж болохгүй. Тэд залхаан цээрлүүлэлт, бусад хэлбэрийн сүрдүүлэг дарамтад өртөх ёсгүй ба тэдний тоног төхөөрөмж, хэрэгслийг хурааж авах, эсхүл гэмтээхгүй байх ёстой. Цуглааныг хууль бус гэж зарласан, эсхүл цуглааныг тараасан ч, тэр нь хяналт тавих эрхийг хязгаарлахгүй, цуцлахгүй. Хүний эрхийн бие даасан үндэсний байгууллагууд болон төрийн бус байгууллагууд цуглаанд мониторинг хийх нь сайн туршлага юм.

31. Оролцогч улсууд нь тайван цуглах эрхийг хэрэгжүүлэх анхдагч үүргийг хүлээнэ. Гэсэн хэдий ч, бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа болон ажилчдынхаа нөлөөгөөр хамт олны тайван жагсаал цуглаан хийх эрхийг зэрэг хүний эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Хувийн хэвшлийн байгууллагууд болон олон нийт энэхүү эрхийг хэрэгжүүлсний буюу эдэлсний үр дүнд гарах тодорхой хэмжээгээр тайван байдал алдагдах явдлыг хүлээн зөвшөөрч болох юм.

32. Тайвнаар хуран цуглах нь ихэнхдээ өөрсдийгөө илэрхийлэх чиг үүрэгтэй, мөн улс төрийн асуудлаар байр сууриа илэрхийлэх нь өөрийгөө илэрхийлэх хэлбэрийн хувьд онцгой хамгаалалт эдэлдэг тул, улс төрийн утга бүхий үзэл санаа хүргэж буй цуглаан нь өндөр түвшний зохицуулалт, хамгаалалт эдлэх нь зүйтэй.

33. 21 дүгээр зүйл ба түүнтэй холбоотой эрхүүд нь цуглаан болж байгаа болон цаашид үргэлжлэх үед оролцогчдыг дан ганц хамгаалдаггүй. Цуглааны шууд нөхцөл байдлаас гадуур хэдий ч, хувь хүн, эсхүл нэг хэсэг бүл хүмүүсийн явуулсан, энэхүү эрхийг утга учиртай эдлэхэд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа ч бас үүнд хамаарна. Оролцогч талуудын буюу улсуудын хүлээх үүргүүд нь иймд оролцогчид, эсхүл зохион байгуулагчдын нөөц боломжийг дайчлах өргөн хүрээний үйл ажиллагаануудаар илэрнэ. Тухайлбал, төлөвлөх, удахгүй болох арга хэмжээний талаарх мэдээлэл түгээх, арга хэмжээнд бэлтгэх, аялах, хуран цуглахын өмнө ба үед оролцогчдын дунд харилцаа холбоог бий болгох, цуглааны талаарх болон цуглааны үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, дараа нь цуглааныг орхих зэрэг болно. Эдгээр үйл ажиллагаа, тухайлбал, цуглаанд оролцохын нэгэн адил, тодорхой хил хязгаартай байх боловч эдгээр нь нарийн тусгагдсан байх ёстой. Түүнчлэн, тайван цуглаанд оролцсон, эсхүл гишүүнчлэгдсэний улмаар хэн ч доромжлогдох, гадуурхагдах, дарамтлуулах ёсгүй.

34. Холбогдох олон үйл ажиллагаа цахимаар эсхүл тоон систем бүхий үйлчилгээнээс хамааралтай байддаг. Эдгээр үйл ажиллагаа ч мөн 21 дүгээр зүйлд заасны дагуу хамгаалагддаг. Оролцогч улсууд нь, тухайлбал, тайван цуглаантай холбоотой интернэт холболтыг хааж, саад болох ёсгүй. Түүнчлэн, энэ нь контентод нэвтрэх эрх болон холболтод тусгай технологийн болон зорилтот газарзүйн замаар хөндлөнгөөс оролцох зэрэгт мөн хамаарна. Улс орнууд нь, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч болон зуучлагчдын үйл ажиллагаа нь цуглааныг зүй бусаар хязгаарлахгүй, мөн цуглаанд оролцогчдын хувийн нууцыг хамгаалахыг баталгаажуулах ёстой. Мэдээлэл түгээх системийн үйл ажиллагаанд тавих аливаа хязгаарлалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хязгаарлалттай нийцэж байх ёстой.

35. Төрийн бүх байгууллагууд тайван цуглах эрхийг хүндэтгэх, хангах үүрэгтэй бол цуглааны талаарх шийдвэр нь ихэвчлэн орон нутгийн түвшинд гардаг. Иймд, улс орнууд нь засгийн газрынхаа бүх түвшинд эдгээр шийдвэрт хамрагдах албан тушаалтнуудыг зохистой сургалт, хангамж, нөөцөөр хангах ёстой.

IV. Тайван хуран цуглах эрхийг хязгаарлах нь

36. Зарим гарцаагүй тохиолдолд тайван хуран цуглах эрхийг хязгаарлаж болох бөгөөд тэдгээр хязгаарлалтыг зөвтгөх нь эрх баригчдын заавал хүлээх үүрэг юм. Эрх баригчид аливаа хязгаарлалт нь хууль ёсны шаардлагыг хангаж байгаа эсэхийг харуулах чадвартай байх ёстой бөгөөд доор дурдсанчлан 21 зүгээр зүйлд зүйлчлэгдсэн хязгаарлалтуудын зөвшөөрөгдөх үндэслэлүүдийн дор хаяж аль нэгтэй нь эн тэнцүү, эсхүл тухайн шаардлагыг хангасан байх ёстой. Энэ үүргийг биелүүлээгүй тохиолдолд 21 дүгээр зүйлийг зөрчсөнд тооцно. Аливаа хязгаарлалтыг ногдуулахдаа шаардлагагүй, зохисгүй хязгаарлалтыг тогтоохоос илүүтэйгээр эрхийг нь хөнгөвчлөх зорилтыг удирдлага болгоно. Хязгаарлалт нь үл ялгаварлан гадуурхсан, эрхийн мөн чанарыг үл алдагдуулсан, цуглаанд оролцохоос үл татгалзсан, эсхүл ноцтой үр дагавар үл учруулахуйц байх ёстой.

37. Тодорхой цуглааныг хориглох нь зөвхөн эцсийн шатны арга хэмжээнд тооцогдоно. Цуглаанд хязгаарлалт тавих нэн шаардлагатай гэж үзвэл эрх баригчид хамгийн интрузив буюу хор хөнөөл бага учруулах арга хэмжээ авахыг эрэлхийлэх нь зүйтэй. Улс орнууд нь дараа нь бүх эрсдлийг арилгахын тулд урьдчилан хязгаарлалт хийхээс илүүтэйгээр цуглаан зохион байгуулахыг зөвшөөрөх, үйл ажиллагааны явцад гарч болзошгүй зөрчлүүдийн талаар авах арга хэмжээнүүдийнхээ талаар бодолцох нь зүйтэй.

38. Тайван цуглаанд оролцохтой холбоотой аливаа хязгаарлалт нь оролцогчид болон холбогдох цуглааны төлөв байдлын ялгаатай байдал, эсхүл хувь хүний үнэлгээнд үндэслэсэн байх ёстой. Тайван цуглаанд өргөн цар хүрээг хамарсан хязгаарлалт хийх нь зохисгүй.

39. 21 дүгээр зүйлийн хоёр дахь өгүүлбэрт дурдсанчлан, тайван хуран цуглах эрхийг хэрэгжүүлэх хуулинд заасан хязгаарлалтаас өөр хязгаарлалт тавьж болохгүй. Ингэснээр, хязгаарлалтууд нь Пактын бусад зүйлд зүйлчлэгдсэнчлэн “хуулиар заасан” байх ёстой гэсэн шаардлагад нийцсэн хууль ёсны байх албан шаардлагыг тавьдаг. Иймд, хязгаарлалтыг хуулиар, эсхүл хуульд заасанд үндэслэн захиргааны шийдвэрээр тогтоох ёстой. Энэхүү хуулиуд нь нийгмийн гишүүдэд үйл ажиллагаагаа хэрхэн зохицуулахаа шийдэх боломжийг олгоход хангалттай нарийн тодорхой байх ёстой бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хүмүүст хязгаарлалтгүй, өргөн цар хүрээтэй эрх мэдэл олгохгүй байж болно.

40. 21 дүгээр зүйлд заасанчлан, аливаа хязгаарлалт нь “ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай” байх ёстой. Тиймээс хязгаарлалт нь дан ганц үндэслэлтэй, оновчтой байхын оронд ардчилал, эрх зүйт ёс, улс төрийн олон ургальч үзэл, хүний эрхэд суурилсан нийгмийн тухайд зайлшгүй шаардлагатай мөн зохистой байх ёстой. Ийм хязгаарлалт нь 21 дүгээр зүйлд жагсаасан зөвшөөрөгдсөн үндэслэлүүдийн аль нэгтэй холбоотой нийгмийн тулгамдсан хэрэгцээнд тохирсон хариу арга хэмжээ байх ёстой. Тэдгээр нь холбогдох хамгаалалтын чиг үүргийг хэрэгжүүлж чадах арга хэмжээнүүдийн дунд хамгийн багаар залхаан цээрлүүлсэн байх ёстой. Үүнээс гадна, тэдгээр нь зохистой байх ёстойн сацуу хөндлөнгөөс оролцсон үндэслэлүүдийн нэгд эсрэг үр нөлөө үзүүлсэнтэй эсрэгцүүлэн тухайн эрхийг хэрэгжүүлэхэд хөндлөнгийн оролцоо нь хор хөнөөлтэй үр дүн, тэдгээрийн мөн чанарыг тооцоолох төдийгүй үнэ цэний үнэлгээ хийхийг шаарддаг. Учруулах хор хөнөөл нь үр ашгаас давсан нөхцөлд тухайн хязгаарлалт нь зохисгүй бөгөөд үл зөвшөөрөгдөнө.

41. 21 дүгээр зүйлийн хоёр дахь өгүүлбэрийн сүүлийн хэсэгт тайван цуглах эрхийг хязгаарлаж болох хууль ёсны үндэслэлийг тодорхойлсон болно. Энэ бол дараах үндэслэлүүдээс бүрдсэн бүрэн жагсаалт юм: үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол; олон нийтийн аюулгүй байдал; олон нийтийн дэг журам; нийгмийн эрүүл мэнд, ёс суртахууны хамгаалалт; эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах.

42. Хэрэв баттай мэдэгдсэн аюул заналхийлэл, эсхүл хүч хэрэглэхийн эсрэг, тухай улс өөрсдийн үндэстний оршин тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолыг хамгаалах чадавхийг хадгалах зорилготой бол, энэхүү хязгаарлалт нь нэн шаардлагатай бөгөөд “үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол” ийм хязгаарлалтын язгуур шалтгаан болж болно. Энэхүү босгыг зөвхөн “тайван” цуглаанд онцгой байдлаар хангаж өгөх нь зүйтэй. Үүнээс гадна, хэрэв үндэсний аюулгүй байдал дордож буйн шалтгаан нь хүний эрхийг таслан зогсоох явдал бол, үүнийг цаашид хязгаарлалтаар, тухайлбал, тайван цуглах эрхийн хязгаарлалтаар, зөвтгөж ашиглаж болохгүй.

43. “Олон нийтийн аюулгүй байдал”-ын хамгаалалтыг тайван цуглах эрхийг хязгаарлах үндэслэл болгон ашиглахын тулд, уг цуглаан нь хүмүүсийн аюулгүй байдалд, хүний амь нас, хувийн аюулгүй байдалд бодитой, ноцтой эрсдэл учруулж байгааг, эсхүл эд хөрөнгөд ноцтой хохирол учруулахтай ижил төстэй эрсдлийг үүсгэж буйг нотолсон байх ёстой.

44. “Нийтийн дэг журам” гэдэг нь нийгмийн зохистой үйл ажиллагааг хангаж буй дэг журмуудын нийлбэр буюу нийгмийг бүтээн байгуулсан үндсэн зарчмуудын бүрдэл бөгөөд энэ нь хүний эрхийг, тэр дундаа тайван хуран цуглах эрхийг хүндэтгэдэг. Оролцогч улсууд тайван замаар цуглах эрхийг өргөн хүрээнд хязгаарлахын тулд “олон нийтийн дэг журам” гэсэн тодорхой бус буюу бүдэг тодорхойлолтод найдах нь зүй бус юм. Зарим тохиолдолд тайван цуглаан, цуглаан нь угаасаа, эсхүл санаатайгаар үймээн дэгдээж болох бөгөөд энэ нь ихээхэн хүлээц шаарддаг. “Олон нийтийн дэг журам”, “хууль, дүрэм журам” гэдэг үгс нь ижил утгатай үгс биш бөгөөд тэдгээрийг дотоодын хууль тогтоомжинд заасан “олон нийтийн эмх замбараагүй байдал”-ын хоригийг тайван цуглаан, цуглааныг хязгаарлах зорилгоор зүй бусаар ашиглагдах ёсгүй.

45. “Нийгмийн эрүүл мэнд”-ийн хамгаалалт нь, хэрэв халдварт өвчний дэгдэлт өргөн цар хүрээг хамарч, олноор цуглах нь аюултай үед, хязгаарлалт тавих үндэслэл байж болох юм. Зарим маш онцгой тохиолдолд, тухайлбал хуран цуглах үеэр эрүүл ахуйн байдал нь олон нийтэд, эсхүл оролцогчдын эрүүл мэндэд ихээхэн эрсдэл учруулж болзошгүй бол, үүнд бас хамаарна.

46. Тайван хуран цуглах тавих хязгаарлалт нь зөвхөн “ёс суртахуун”-ыг хамгаалах, хангах зорилгоор байж болно. Хэрэв энэ үндэслэлийг огт ашиглахгүй бол дан ганц нийгэм, гүн ухаан, эсхүл шашны уламжлалаас үүдэлтэй ёс суртахууны талаарх ойлголтыг хамгаалахад ашиглаж болохгүй бөгөөд ийм хязгаарлалтыг хүний эрх, олон ургалч үзэл, үл ялгаварлан гадуурхах зарчмын үүднээс ойлгох ёстой. Жишээлбэл, бэлгийн чиг баримжаа, эсхүл жендер айдентити (gender identity) буюу хүйсийн баримжаагаа илэрхийлсний эсрэг гэх мэт үндэслэлээр хязгаарлалт тавьж болохгүй юм.

47. “Бусдын эрх, эрх чөлөө”-г хамгаалах зорилгоор тавьсан хязгаарлалт нь уг гэрээнд заасан хамгаалалт, эсхүл цуглаанд оролцоогүй хүмүүсийн бусад хүний эрхэд хамааралтай байж болно. Түүнчлэн, цуглаан нь нийтийн болон бусад орон зайг хууль ёсны дагуу ашиглах явдал. Тайван цуглаан нь мөн чанараараа ердийн амьдралд тодорхой хэмжээний саад тотгор учруулж болзошгүй ч тэдгээр зөрчил нь зохистой бус ачааллыг үзүүлээгүй тохиолдолд тэр саад тотгорыг хүлээн зөвгөөрөх нь зүйтэй. Хэрэв эрх баригчид аливаа хязгаарлалт хийсэн тохиолдолд түүнийгээ маш тодорхой, дэлгэрэнгүй тайлбарлан, баримтаар хангах ёстой.

48. Дээр дурдсанчлан 21 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын ерөнхий хүрээнээс гадна нэмэлт үзүүлэлтүүд нь тайван цуглах эрхийг хязгаарлахтай хамааралтай, холбоотой байна. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх цөм нь, аливаа хязгаарлалтын зарчмын хувьд төвийг сахьсан байх шаардлага бөгөөд улмаар цуглаанаар дамжуулж буй үзэл санаа, мэдэгдэлтэй холбоогүй байх юм. Аливаа эсрэг арга аргачлал нь, хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх, дэвшүүлэх, тэдний дэмжлэгийн цар хүрээг тогтоох боломжийг олгодог улс төр, нийгмийн оролцооны боломжит хэрэгсэл болох тайван цуглааны үндсэн зорилгыг үгүй хийдэг.

49. Цуглаануудын аливаа илэрхийлэх элементүүдтэй харьцахдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хамаарах дүрмүүдийг дагаж мөрдөх ёстой. Иймд тайван цуглаанд тавьж буй хязгаарлалтууд нь засгийн газрынхаа улс төрийн үзэл баримтлалын эсрэг байр сууриа илэрхийлэх, эрх мэдэлд сорилт хийх, үүнд засгийн газрын, үндсэн хуулийн, эсхүл улс төрийн системийг ардчилсан байдлаар өөрчлөх уриалгууд, эсхүл бие даан шийдвэр гаргахыг зогсооход ашиглагдах ёсгүй. Эдгээрийг албан тушаалтан, төрийн албан байгууллагын нэр төр, алдар хүндэд халдахыг хориглоход ашиглаж болохгүй.

50. Пактын 20 дугаар зүйлд заасны дагуу, тайван цуглааныг дайны ухуулга сурталчилгаанд (20 дугаар зүйлийн 1), ялгаварлан гадуурхах, дайсагнал, хүчирхийллийг өдөөдөг үндэсний, арьс өнгөний, шашны үзэн ядалтыг сурталчлахад (20 дугаар зүйлийн 2) ашиглаж болохгүй. Ийм тохиолдолд, аль болох, цуглаанд бүхэлд нь биш, харин буруутай хувь хүнд арга хэмжээ авах нь зүйтэй. 20 дугаар зүйлийн хүрээнд давамгайлсан мессеж орсон цуглаанд оролцох асуудлыг 19, 21 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын шаардлагын дагуу шийдвэрлэх ёстой.

51. Ерөнхийдөө, далбаа, дүрэмт хувцас, тэмдэг, баннер ашиглах нь хэдийгээр гашуун түүхийг санагдуулахуйц байвч үүнийг хязгаарлах ёсгүй бөгөөд илэрхийллийн хууль ёсны хэлбэр гэж үзэх ёстой. Зарим нэг маш онцгой тохиолдолд, эдгээр тэмдэг нь ялгаварлан гадуурхалт, дайсагнал, хүчирхийллийг өдөөхтэй шууд ба зонхилон холбогдсон байх үед зохих хязгаарлалтыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

52. Ерөнхийдөө, цуглаан нь олон нийтийн гишүүдийн зүгээс оролцогчдын эсрэг дайсагналыг өдөөж байгаа, эсхүл өдөөж болзошгүй байдал нь хязгаарлалтыг зөвтгөхгүй. Цуглаанаа үргэлжлүүлэхийг зөвшөөрөх ёстой бөгөөд оролцогчид ч хамгаалагдах ёстой (дээрх 18 дугаар хэсгийг харна уу). Гэвч, оролцогч улсууд, маш онцгой нөхцөлд, тухайлбал, оролцогчдын аюулгүй байдалд ноцтой аюул заналхийлэл учрахаас хамгаалах боломжгүй үед, цуглаанд оролцохыг нь хязгаарлаж болно. Ийм аливаа хязгаарлалт нь хатуу хяналтыг тэсвэрлэх чадвартай байх ёстой. Хүчирхийллээс үүдсэн тодорхойгүй эрсдэл, эсхүл эсэргүүцэгчдээс үзүүлж буй хүчирхийллээс уг цуглааныг урьдчилан сэргийлэх, саармагжуулах чадвар эрх барих байгууллагад байхгүй байгаа нь хангалтгүй. Улс орнууд нь, хэдийгээр тэдний хууль сахиулах чадавхи үр дүнтэй ч, нөхцөл байдлыг барьж тогтоож чадахгүй гэдгээ тодорхой эрсдлийн үнэлгээнд тулгуурлан харуулах чадвартай байх ёстой. Хориглохоос өмнө цуглааныг хойшлуулах, нүүлгэн шилжүүлэх гэх мэт аль болох хор хөнөөл багатай арга хэмжээг авахад анхаарах ёстой.

53. Цуглааны цаг, газар, хэв маягийн зохицуулалт нь ерөнхийдөө төвийг сахисан байдаг бөгөөд эдгээр элементүүдийг зохицуулах хязгаарлалтад хязгаар бий ч, ийм хязгаарлалтыг тухайн тохиолдол бүрт зөвтгөх нь эрх бүхий байгууллагуудын үүрэг юм. Ийм аливаа хязгаарлалт нь, аль болох, оролцогчдыг зорилтот бүлгийнхээ хараа, сонор дор, эсхүл зорилгодоо хүрч болох чухал ач холбогдолтой аль ч газарт цуглах боломжийг олгох ёстой.

54. Цуглааны цагийг хязгаарлахтай холбоотойгоор, оролцогчдод үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл бусад зорилгоо үр дүнтэй хэрэгжүүлэх хангалттай боломж олгох ёстой. Тайван хуран цуглаж өндөрлөхийг цуглаанд оролцогчдод өөрсдөд нь даатгах нь зүйтэй. Цуглааныг зохион байгуулах боломжтой, эсхүл боломжгүй тодорхой өдөр, цаг, эсхүл огноонд хязгаарлалт тавих нь цуглаан Пактын заалттай нийцэж байгаа эсэх талаарх асуулт тавих хүргэдэг. Цуглаан нь зөвхөн давтамжаасаа болоод хязгаарлагдах нь зүй бус. Жишээлбэл, жагсаалын цаг хугацаа, үргэлжлэх хугацаа, эсвэл давтамж нь зорилгодоо хүрэхэд гол үүрэг гүйцэтгэж болно. Гэсэн хэдий ч, хязгаарлалтын зохистой байдлын үнэлгээгээр тогтвортой цуглааны нийт үр нөлөөг жинлэж болно. Жишээ нь, шөнийн цагаар орон сууцны хорооллуудад тогтмол хийгддэг цуглаан ойр орчинд нь амьдардаг хүмүүст ихээхэн нөлөөлдөг.

55. Байршлын хувьд хязгаарлах тухайд, зарчмын хувьд, олон нийтийн талбай, гудамж гэх мэт олон нийтийн нэвтрэх эрхтэй, эсхүл нэвтрэх боломжтой бүх газарт тайван цуглааныг явуулж болно. Барилга, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт зарим орон зайд олон нийтийн нэвтрэх журмын дагуу хуран цуглах эрхийг хязгаарлаж болох боловч ийм хязгаарлалтыг тайван цуглаанд тавих бол 21 дүгээр зүйлийн дагуу зөвтгөх ёстой. Тайван цуглаан нь өөрсдийн зорилтот бүлгийн, эсхүл олон нийтийн анхаарлыг үр дүнтэй татаж чадахгүй байсан ч тэднийг алслагдсан газарт шилжүүлж болохгүй. Ерөнхий дүрмийн дагуу, нийслэл хот доторх бүх нийтийн цуглаан, хотын доторх тодорхой байршил, хотын төвийн гадна талд, эсхүл хотын бүх гудамжинд болж буй цуглаанд өргөн хүрээтэй хориг тавьж болохгүй.

56. Олон нийтийн газар болох шүүх, парламент, түүхэн ач холбогдол бүхий газрууд эсвэл бусад албан байгууллагуудын барилга байгууламжууд нь олон нийтийн орон зай тул цуглааныг зохион байгуулуулахаас зайлсхийх хэрэгтэй. Ийм газар болон түүний эргэн тойрон дахь цуглаанд тавих аливаа хязгаарлалтыг тусгайлан зөвтгөх, мөн тэдгээрийг нарийвчлан тодорхойлсон байх ёстой.

57. Хувийн орон сууцанд цуглах нь тайван цуглах эрхийн хүрээнд хамаарах боловч өмчлөх эрх бүхий бусдын ашиг сонирхлыг зохих ёсоор нь хангах ёстой. Ийм цуглаанд ямар хязгаарлалт тогтоож болох нь хараа, сонор дор гэдэг зарчимд тулгуурласны үндсэн дээр тухайн орон зай нь тогтмол, олон нийтэд хүртээмжтэй байгаа эсэх, үл хөдлөх хөрөнгийн эрх болон бусдын ашиг сонирхлын үүднээс уг цуглаанаас үүдэн гарч болзошгүй хөндлөнгийн шинжтэй мөн чанар, цар хүрээ болон үл хөдлөх хөрөнгийн эзэшигч нь уг ашиглалтыг зөвшөөрч байгаа эсэх, тухайн талбайн өмчлөл нь уг цуглаанаар маргаан тарьж байгаа эсэх, оролцогчдод цуглааны зорилгодоо хүрэх бусад боломжит арга хэрэгсэл байгаа эсэх гэж мэт зүйлсийг харгалзан үзсэний үндсэн дээр тавигдах ёстой. Хувийн өмчид нэвтрэхийг ялгаварлан гадуурхаж болохгүй.

58. Тайван хуран цуглах хэв маягийн талаарх хязгаарлалтуудыг нэгэнт анхаарч үзсэн тохиолдолд, оролцогчдод өөрсдийн мессэжийг, мэдээллийг дамжуулахын тулд зурагт хуудас, мегафон, хөгжмийн зэмсэг, эсхүл гэрэл тусгах хэрэгсэл гэх мэт техникийг ашиглах эсэхээ шийдэх эрхийг тэдэнд үлдээх нь зүйтэй. Цуглаан үзэгч, сонсогчдооо хүрэх, эсвэл зорилгоо биелүүлэхийн тулд дууны систем гэх мэт байгууламжуудыг түр байршуулж болно.

59. Ерөнхийдөө, оролцогч улсууд цуглаанд оролцох оролцогчдын тоог хязгаарлаж болохгүй. 21 дүгээр зүйлд заасан хязгаарлалт тавих үндэслэлүүдтэй хууль, дүрмийн дагуу холбогдож байгаа бол, тухайлбал, цэнгэлдэх хүрээлэн, эсхүл гүүрэн дээр хуран цуглах хүмүүсийн хамгийн дээд багтаамжийг олон нийтийн аюулгүй байдлын үүднээс, эсхүл өөр хоорондоо зай барихыг шаарддаг нийгмийн эрүүл мэндийн асуудлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр ийм хязгаарлалтыг хүлээн зөвшөөрнө.

60. Цуглаанд оролцогчид амны хаалт зүүх, малгай өмсөх зэргээр нүүрээ хаах, бусад байдлаар өөрийгөө өнгөлөн далдлах, нэрээ нууцлан цуглаанд оролцох зэрэг нь тайван цуглааны илэрхийлэх элементүүдийн нэг бөгөөд энэ нь хэлмэгдүүлэлт, залхаан цээрлүүлтийг эсэргүүцэх, мөн тандалтын шинэ технологи ашиглаж байгаа үед хувийн нууцлалаа хамгаалахад ашиглагдаж болно. Хэрэв тэдний үйлдэл нь баривчлах үндэслэл болоогүй бол оролцогчдын нэрээ нууцлахыг зөвшөөрнө. Хэрэв нүүр царайгаа далдлах нь дээр дурдсан хоригуудын нэг биш бөгөөд тэдэнд ижил төстэй өөр шалтгаан байгаа бол оролцогчдын мөн нэрээ нууцлахыг зөвшөөрнө (51 дүгээр хэсгийг үзнэ үү). Далдлалтыг ашиглах нь өөрөө хүчирхийллийн сэдлийг илэрхийлж байна гэж үзэж болохгүй.

61. Эрх бүхий байгууллагуудын цуглаантай холбоотой мэдээлэл, өгөгдлийг цуглуулах нь тодорхой нэг нөхцөл байдалд тэдэнд тусалж болох ч энэ нь тэдний эрхийг зөрчих, сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага байхаас үл хамааран, тэдний тандалтын технологи ашиглах замаар, эсхүл харилцаа холбоог нь таслан зогсоох аргаар цуглуулсан аливаа мэдээлэл нь,

тухайн мэдээллийг цуглуулсан, бусдад хуваалцсан, хадгалсан, нэвтэрсэн арга зам нь олон улсын хэм хэмжээнд нийцсэн, тэр дундаа хувийн нууцлалын талаарх эрхийг хангасан байх ёстой бөгөөд цуглаанд оролцогчдын болоод ирээдүйд оролцох хүмүүсийг айлган сүрдүүлсэн, дарамталсан зорилготой хэзээ ч байж болохгүй. Ийм тогтсон үйл ажиллагаанууд нь олон улсын жишигт нийцсэн, шүүхээр хянан шийдвэрлэгддэг, зохистой, олон нийтэд хүртээмжтэй хууль эрх зүйн орчноор зохицуулагдах нь зүйтэй.

62. Аливаа цуглаан олон нийтийн газар зохион байгуулагдаж байгаа нь оролцогчдын хувийн нууцад халдаж болно үг биш юм. Жишээ нь, нүүр царай таних болон бусад технологийн тусламжтайгаар цугласан хүмүүсийг таниж болох бөгөөд энэ нь хувийн нууцаа хадгалах эрхийг нь зөрчиж болох юм. Мөн тайван цуглаанд оролцох талаарх мэдээллийг олж авахын тулд цахим мэдээллийг хэрэгслийг хянахад ч мөн адил хамааралтай. Тайван цуглаанд оролцож буй хүмүүсийн хувийн мэдээллийг цуглуулах шийдвэр, тэдгээрийг хуваалцах, хадгалах үйл явцыг бие даасан, ил тод хяналт, шинжилгээний үндсэн дээр хийх ёстой бөгөөд эдгээр үйлдлүүд нь Пакттай нийцэж байгаа эсэхийг шалгах ёстой.

63. Төрийн албан хаагчдын тайван цуглаанд оролцох эрх чөлөөг олон нийтийн зүгээс тэдний үнэнч шударга байдал, албан үүргээ гүйцэтгэх чадварт итгэх итгэлийг хангах хэрэгцээ шаардлагаас илүүтэйгээр хязгаарлах нь зүй бус бөгөөд ийм аливаа хязгаарлалт нь 21 дүгээр зүйлд нийцэж байх ёстой.

64. Оролцогчид эсхүл зохион байгуулагчид нь цагдаа хүчний, эсхүл харуул хамгаалалтын, эрүүл мэндийн тусламжийн эсвэл цэвэрлэгээний, эсхүл тайван цуглаантай холбогдох бусад олон нийтийн үйлчилгээний зардлыг зохицуулах эсхүл үүнд хувь нэмэр оруулах ёстой гэдэг шаардлага нь 21 дүгээр зүйлд үл нийцнэ.

65. Зохион байгуулагчид, оролцогчид нь тайван цуглаантай холбоотой хууль ёсны шаардлагуудыг биелүүлэх ёстой бөгөөд бусдыг уриалан дуудах гэх мэт хууль бус үйлдлийнхээ төлөө тэд хариуцлага хүлээж болно. Хэрэв, маш онцгой нөхцөл байдалд, өөрсдөө шууд хариуцлага хүлээхгүй гэмтэл, ослын улмаас зохион байгуулагчид хариуцлага хүлээдэг бөгөөд энэ нь хохирол, сүйрлийг зохион байгуулагчид урьдчилан харж, сэргийлж болох байсныг баримт нотолгоогоор баталсан тохиолдолд, тэдэнд хориг тавих ёстой. Зохион байгуулагчид нь, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа эрхлэгч, удирдагчийг томилох нь сайн туршлага ч энэ нь хууль ёсны шаардлага байх ёсгүй.

66. Эрх баригчид хувь хүмүүсээс ирээдүйн цуглааныг зохион байгуулахгүй, эсхүл түүнд оролцохгүй байх амлалт авах, эсхүл ямарваа үйлдэл үл хийхийг шаардахгүй байх. Эсрэгээрээ, хэн ч цуглаанд албадлагаар оролцох ёсгүй.

67. Хууль бус үйлдэл хийснийх нь төлөө тайван цуглааныг зохион байгуулагчид, эсхүл оролцогчдод эрүүгийн болон захиргаан шийтгэл ногдуулах бол энэ нь зохистой, ялгаварлан гадуурхсан шинжгүй байх ёстой бөгөөд хоёрдмол утгатай, эсхүл хэт өргөн хүрээнд тодорхойлсон гэмт хэрэгт үндэслэгдээгүй байх, эсхүл Пактын дагуу хамгаалагдсан зан үйлдлийг хорихгүй байх ёстой.

68. Терроризмын үйлдлүүдэд олон улсын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой боловч энэ төрлийн гэмт хэргийн тодорхойлолт нь хэт өргөн хүрээний, эсхүл ялгаварлан гадуурхсан байх ёсгүйн сацуу тайван хуран цуглах эрхийг эдлэх, хэрэгжүүлэхийг үл дэмжсэн, эсвэл хасах зорилгоор ашиглагдах ёсгүй. Тайван цуглааныг зохион байгуулах, эсхүл үүнд оролцох ердийн үйлдэл нь терроризмын эсрэг хуулиар эрүүгийн хариуцлагад татагдах ёсгүй.

69. Хязгаарлалт тавигдсантай холбоотой хариу арга хэмжээ авах үүднээс шүүх болон бусад шүүхийн байгууллагад хандах орчин бүрдсэн, боломж олгогдсон байх ёстой бөгөөд үүнд давж заалдах, эсхүл эргэн хянах арга хэмжээг багтааж болно. Цуглаанд хориг тавихын эсрэг ийм ажиллагааны цаг хугацаа, үргэлжлэх хугацаа нь тухайн эрхийг эдлэхэд нь аюул учруулах ёсгүй. Пактын журамласан, шат дараалсан баталгаанууд нь ийм бүх тохиолдолд хүчинтэй бөгөөд түүнчлэн тайван цуглаантай холбогдуулан саатуулах, шийтгэл оногдуулах зэрэг асуудалд ч мөн адил хамаарна.

V. Мэдэгдлийн буюу мэдэгдэх горимууд

70. Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах нь, тайван хуран цуглах нь үндсэн эрх гэсэн санааг сулруулдаг. Тайван цуглааныг зохион байгуулахаар зорьж буй хүмүүс эрх бүхий байгууллагуудад урьдчилан мэдэгдэх, нэн шаардлагатай мэдээллээр сайтар хангах ёстой гэж шаарддаг мэдэгдэх тогтолцоо нь цуглааныг хэвийн явуулах, бусдын эрхийг хамгаалахад нь эрх бүхий байгууллагуудад туслах шаардлагын дагуу зөвшөөрөгддөг. Үүний зэрэгцээ, энэхүү шаардлагыг тайван цуглааныг таслан зогсоох зорилгоор буруугаар ашиглах ёсгүй бөгөөд бусдын эрхэнд хөндлөнгөөс оролцсон тохиолдолд л 21 дүгээр хэсэгт жагсаасан үндэслэлүүдийн дагуу зөвтгөх ёстой. Мэдэгдлийн шаардлагыг хэрэгжүүлэх нь эцсийн зогсоол биш юм. Мэдэгдэх үйл явц нь хүнд сурталгүй, ил тод байх ёстой бөгөөд зохион байгуулагчдад тавих тэдний шаардлага нь тухайн цуглааны олон нийтэд үзүүлж болзошгүй нөлөөлөлтэй дүйцэхийн сацуу үнэ төлбөргүй байх ёстой.

71. Шаардсанчлан, зохион байгуулах гэж буй цуглааны талаар эрх бүхий байгууллагуудад урьдчилан мэдээлэх нь бүтэлгүйтэх нь тухайн цуглаанд оролцох оролцоог хууль бус гэж үзэх үндэслэл биш бөгөөд энэ нь цуглааныг тараах, оролцогчид болоод зохион байгуулагчдыг баривчлах, эсхүл зохион байгуулагч, оролцогчдод эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэх мэт зохисгүйгээр хориг тавих үндэслэл болох ёсгүй. Мэдэгдэл өгөөгүйн төлөө зохион байгуулагчдад захиргааны шийтгэл оногдуулах тохиолдолд, үүнийг эрх бүхий байгууллагууд баримт нотолгоогоор батлах ёстой. Мэдэгдлээ дутуу өгөх нь эрх бүхий байгууллагууд өөрсдийн чадавхийн хүрээнд цуглааныг чиглүүлэх, эсвэл оролцогчдыг хамгаалах үүргээс нь чөлөөлөхгүй.

72. Урьдчилан төлөвлөсөн цуглаанд тавигдах мэдэгдлийн шаардлагыг дотоодын хууль тогтоомжид заасан байх ёстой. Урьдчилан мэдэгдэх хамгийн бага хугацаа нь шаардлагатай нөхцөл байдал, түвшингээс хамааран өөр өөр байж болох ч энэ нь хэт урт байх ёсгүй. Хэрэв мэдэгдэл өгсний дараа хориг тавивал шүүхэд хандах хугацаа, эсвэл тэдгээрийг сорих бусад механизмыг олгохын тулд эрт мэдэгдэх нь зүйтэй. Аливаа мэдэгдлийн дэг журам нь, цуглааны үр нөлөө нь бусдад харьцангуй бага, тухайлбал, тухайн цуглааны мөн чанар, байршил, хязгаарлагдсан хэмжээ, хугацаа гэх мэт хамгийн багаар тооцсон цуглааныг үл хамааруулна. Мэдэгдэл өгөх хангалттай хугацаа байхгүй, цагийн шаардлагаар аяндаа үүссэн цуглаанаас мэдэгдлийг шаардах ёсгүй.

73. Зөвшөөрөл буюу эрх олгох дүрэм журам нь дотоодын хууль тогтоомжинд бий үед, тэдгээр нь мэдээллийн тогтолцооны хэлбэрээр ажиллах ёстой бөгөөд зөвшөөрөл олголт нь хүндэтгэх өөр шалтгаангүй үед тогтсон ёсоор олгогдох нь зүйтэй. Мэдэгдэл өгөх дэг журмууд нь зөвшөөрөл өгөх тогтолцооны хэлбэрээр ажиллах ёсгүй.

VI. Хууль сахиулах байгууллагуудын бүрэн эрх ба үүрэг хариуцлага

74. Цуглааны хэв журмыг сахиулах үйл ажиллагаанд оролцож буй хууль сахиулах байгууллагын ажилтнууд зохион байгуулагч, оролцогчдын үндсэн эрхийг хүндэтгэж, хэрэгжилтийг хангаж, сэтгүүлч, хянагч, ажиглагч, эмнэлгийн ажилтнууд болон олон нийтийн бусад гишүүд, мөн нийтийн болон хувийн өмчийг хохирлоос хамгаалах ёстой. Эрх баригчдын үндсэн арга барил нь шаардлагатай тохиолдолд тайван цуглааныг чиглүүлэхийг эрэлхийлэх нь зүйтэй.

75. Холбогдох хууль сахиулах байгууллагууд бэлэн байдал, хурцадмал байдлыг намжаах, маргааныг шийдвэрлэхэд чиглэсэн цуглаанд оролцохоос өмнө ба цуглааны үеэр оролцож буй янз бүрийн талуудын хооронд харилцаа холбоо, яриа хэлэлцээнд тохирох сувгуудыг бий болгох чиглэлээр аль болох их ажиллах ёстой. Зохион байгуулагчид, оролцогчид ийм холбоог бий болгох нь сайн туршлага боловч тэднээс ийм харилцаа шаардах боломжгүй юм.

76. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг байлцуулах шаардлагатай тохиолдолд цуглааныг зориулалтын дагуу зохион байгуулагдсан, аливаа хүнд учирч болох хохиролыг мөн эд хөрөнгөд учирч болох гарзыг хамгийн бага байлгах аргаар цуглааны хэв журам сахиулах бодлого төлөвлөгдсөн бас зохион байгуулагдсан байх нь зүйтэй. Төлөвлөгөөнд холбогдох бүх албан тушаалтан, нэгжүүдийн байршлуудыг, тэдэнд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг, мөн бүх зааварчилгааг нарийвчлан тусгасан байх ёстой.

77. Холбогдох хууль сахиулах байгууллагууд ерөнхий эрсдлийн төлөвлөгөөнүүд, сургалтын протоколыг боловсруулах нь зүйтэй бөгөөд энэ нь, ялангуяа, цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэлгүй, нийтийн хэв журамд нөлөөлж болзошгүй цуглааны үеэрх хэв журмыг сахиулахад зориулагдаж боловсруулсан байх ёстой. Тодорхой удирдах албаны бүтэц нь үйл явдлыг тэмдэглэх, баримтжуулах, албан тушаалтныг таних, хүч хэрэглэхийг мэдээлэл тайлагнах протоколиудын нэгэн адил хариуцлагыг баталгаажуулахын тулд орших ёстой.

78. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүчирхийлэлд хүргэж болзошгүй нөхцөл байдлыг хурцатгахгүйг эрмэлзэх нь зүйтэй. Тэд хүчирхийлэлгүй арга хэрэгслийг ашиглах, хүч хэрэглэх нь туйлын чухал шаардлагатай бол урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд энэ нь эдгээрийн аль аль нь үр дүнгээ өгөхгүй тохиолдолд юм. Аливаа хүч хэрэглэх нь Пактын 6, 7 дугаар зүйлд хамаарах хууль ёсны, зайлшгүй байдлын, зохистой байдлын, урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхахгүй байх үндсэн зарчмуудтай нийцэж байх ёстой бөгөөд хүч хэрэглэсэн хүмүүс хүч хэрэглэх бүртээ хариуцлага хүлээх ёстой. Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд хүч хэрэглэх тухай дотоодын хууль тогтоомжийн дэглэм нь Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын хүч хэрэглэх, галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Хууль сахиулах үйл ажиллагаанд хор хөнөөл багатай зэвсэг хэрэглэх хүний эрхийн удирдамжийг удирдлага болгон хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын хүч хэрэглэх тухай дотоодын хууль тогтоомжуудыг олон улсын тогтоомжид заасан шаардлагуудад нийцүүлэх ёстой.

79. Цуглааны үеэр хууль сахиулах хууль ёсны зорилгын дагуу шаардлагатай тохиолдолд л шаардлагатай хамгийн бага хүчийг ашиглаж болно. Шаардлагатай хүчийг хэрэглэсэн бол, тухайлбал, хүчирхийлэл үйлдсэн этгээдийг аюулгүй баривчилсан тохиолдолд, цаашид аливаа хүч хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд цуглааныг тараах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эсхүл гэмт хэрэгтэн, сэжигтнийг хууль ёсоор баривчлахад туслах, эсхүл хэрэгжүүлэх гэх мэт хууль ёсны зорилгоо биелүүлэхийн тулд зохистойгоос илүүтэй их хүч хэрэглэхгүй байх нь зүйтэй. Дотоодын хууль тогтоомж нь албан тушаалтнуудад цуглааныг тараахын тулд “хүч”, эсхүл “шаардлагатай бүх хүч”-ийг ашиглах, эсхүл зөвхөн “хөл руу буудах” гэх мэт хязгааргүй эрх мэдлийг олгох ёсгүй юм. Тодруулбал, дотоодын хууль тогтоомж нь цуглаанд оролцогчдыг хүчирхийлэлтэй, хэт их эсхүл ялгаварлан гадуурхсан байдлаар хүч хэрэглэхийг зөвшөөрөх ёсгүй.

80. Цуглааны хэв журам сахиулахад, тэр дундаа хүний эрхийн хэм хэмжээнд сургагдсан, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг ийм зорилгоор байрлуулах нь зүйтэй. Сургалт нь, тайван цуглаанд оролцох үедээ, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт хүмүүсийг зарим тохиолдолд хамруулж болзошгүй, эмзэг байдалд байгаа хувь хүмүүсийн болон бүлгийн тусгай хэрэгцээний талаарх ойлголтыг албан ажилтнуудад өгөх учиртай. Цэргийн алба хаагчдыг цуглааны хэв

журам сахиулахад ашиглах нь зүй ёсны хэрэг биш бөгөөд, тэднийг, онцгой нөхцөл байдалд болон түр хугацаанд, туслах зорилгоор байрлуулах ба тэд хүний эрхийн зохих сургалтад хамрагдсан байх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудтай адил олон улсын дүрэм, хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

81. Цуглааны хэв журам сахиулах бүх хууль сахиулах байгууллагын ажилтнууд нь зохих ёсоор, шаардлагатай нөхцөлд тохиромжтой, зорилгод нийцсэн эд тоноглолоор, тэр дэндаа, үхлийн аюул багатай зэвсэг, хамгаалах хэрэгслээр, тоноглогдсон байх ёстой. Оролцогч улсууд нь, бүх төрлийн зэвсэг, түүний дотор үхлийн аюул багатай зэвсгүүд нь хувь хүний чанд хатуу хяналтаас шууд хамааралтайг, зэвсгээр хангагдсан алба хаагчид тусгай сургалтад хамрагдахыг хангах ёстой, мөн зэвсэгт өртсөн хүмүүсийн эрхүүдтэй хамаатуулж, зэвсгүүдийн үр нөлөөг хянах, үнэлэх ёстой. Хууль сахиулах байгууллагууд нь хэв журам сахиулах тодорхой тактикуудын, тэр дундаа, шинэ технологийг ашиглах үед, гарч болзошгүй ялгаварлан гадуурхсан үр нөлөөнүүдийн талаар сэрэмжтэй байх, мөн тэдгээрийг шийдвэрлэх ёстой.

82. Зорилтот хүмүүсийг цуглаанд оролцохын эсрэг урьдчилсан арга хэмжээ авах үүднээс баривчлан саатуулах нь эрх чөлөөг нь дур зоргоороо үгүй хийхэд тооцогдох бөгөөд энэ нь тайван цуглах эрхтэй нийцэхгүй. Энэ нь, ялангуяа, саатуулах нь цөөнгүй цагаар үргэлжилсэн тохиолдолд хамааралтай. Дотоодын хууль тогтоомжоор ийм саатуулалт буюу цагдан хорихыг зөвшөөрдөг ч үүнийг зөвхөн онцгой тохиолдолд, гарцаагүй шаардлагатай нөхцөлд болон зөвхөн эрх баригчид тодорхой цуглааны үеэр хүчирхийлэл үйлдэх, эсхүл өдөөн турхирах үйлдлүүдэд оролцсон хувь хүмүүсийн санаа сэдлийг нотолсон тохиолдолд л, мөн хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх бусад арга хэмжээ хангалтгүй байгаа нь маш тодорхой үед, зөвшөөрнө. Цуглааны өмнө, цуглааны үеэр, эсхүл дараа нь ялгаваргүйгээр бөөнөөр нь баривчлах нь дур зоргын хэрэг тул хууль бус үйлдэл юм.

83. Цуглаанд оролцож байгаа, эсхүл оролцох гэж байгаа хүмүүст холбогдох “зогсоох ба хайх” болон “зогсоох ба нэгжих” бүрэн эрхийг комиссынхны боломжит сэжиглэл, эсхүл ноцтой гэмт хэрэг үйлдэх аюул заналхийлэлд үндэслэн хэрэгжүүлэх ёстой бөгөөд энэ нь ялгавардан гадуурхсан байдлаар ашиглагдах ёсгүй юм. Эрх баригчид хувь хүнийг тайван цуглаантай холбож байгаа нь тэднийг зогсоох, хайх үндэслэл болох учиргүй юм.

84. Хүрээлэн бүслэх буюу хууль сахиулах байгууллагын алба хаагчид тойрон хүрээлж, оролцогчдын нэг хэсэгт хашихыг зөвхөн шаардлагатай, үүнийг хийх нь зохистой үед, мөн зөвхөн бодит хүчирхийлэл, эсхүл тэр хэсгээс үүдэлтэй айсуу аюулыг арилгахын тулд ашиглах нь зүйтэй. Тодорхой хувь хүмүүст чиглэсэн хууль сахиулах шаардлагатай арга хэмжээнүүд нь ихэнх тохиолдолд тойрон бүслэхээс илүүд тооцогдоно. Зөвхөн хүчирхийлэлд холбоотой хүмүүсийг аль болох бүслэх, мөн бүслэлтийн хугацааг хамгийн бага хэмжээнд байхад онцгой анхаарах ёстой. Бүслэх арга хэмжээг ялгаваргүйгээр, эсхүл шийтгэх хэлбэрээр ашиглах нь тайван хуран цуглах эрхийг зөрчиж буй хэрэг бөгөөд энэ нь түүнчлэн дур зоргоор үл цагдан хорих, чөлөөтэй зорчих гэж мэт бусад эрхийг зөрчиж болзошгүй юм.

85. Зөвхөн онцгой тохиолдолд цуглааныг тарааж болно. Цуглааныг цаашид тайван бус байх нь, эсхүл, зорилтот баривчилгаа гэх мэт илүү зүй зохистой арга хэмжээнүүдийг авч зохистой буюу үндэслэлтэйгээр шийдэж чадахгүй буй, ноцтой хүчирхийллийн айсуу аюулын ноттой баталгаа бий бол, цуглааныг тараах нь эцсийн арга хэмжээ байж болно. Бүх тохиолдолд, хүч хэрэглэх тухай хууль сахиулах дүрмийг чанд мөрдөх ёстой. Цуглааныг тараах тушаалын нөхцлийг дотоодын хууль тогтоомжид тусгасан байх нь зүйтэй бөгөөд зөвхөн зохих ёсны эрх бүхий албан тушаалтан тайван цуглааныг тараах тушаал өгч болно. Замын хөдөлгөөнийг өргөн хүрээнд хаах гэж мэт өндөр түвшний тасалдал буюу эмх замбараагүй байдал үүсгэж буй ч тайван хэвээр боловч үймээн самуун нь, дүрмээр бол “ноцтой бөгөөд урт удаан хугацааны”-х бол цуглааныг тарааж болно.

86. Дотоодын болоод олон улсын хууль тогтоомжийн дагуу цуглааныг тараах шийдвэрийг гаргасан бол хүч хэрэглэхээс татгалзах нь зүйтэй. Энэ нь тухайн нөхцөл байдалд боломжгүй бол, зөвхөн шаардлагатай хамгийн бага хүчийг ашиглаж болно. Аливаа хүчийг аль болох хүчирхийлэл үйлдэж, эсхүл заналхийлж буй тодорхой хувь хүн, бүлгийн эсрэг чиглүүлэх нь зүйтэй. Маш хөнгөнөөс илүүгүй гэмтэл учруулж болох хүчийг идэвхгүйгээр эсэргүүцэж буй хувь хүн, бүлгүүдэд ашиглахгүй байх нь зүйтэй.

87. Нулимс асгаруулагч, усан буу гэх мэт өргөн цар хүрээтэй нөлөө бүхий, үхлийн бага аюултай зэвсэг нь ялгаварлан гадуурхах нөлөөтэй байх хандлагатай. Тэдгээр зэвсгүүдийг хэрэглэсэн бол олныг үймүүлэх, эсхүл ойр орчмын хүмүүст хор хохирол оруулах гэх мэт эрсдлийг хязгаарлахын тулд бүх боломжит хүчин чармайлтаа дайчлах нь зүйтэй. Тэдгээр зэвсгүүдийг, зөвхөн аман анхааруулга, мөн оролцогчдод тарах хангалттай боломж олгосны дараа л, эцсийн арга хэмжээ болгон ашиглах ёстой. Хязгаарлагдмал орчинд нулимс асгаруулагч хий ашиглаж болохгүй.

88. Галт зэвсэг нь цуглааны хэв журам сахиулахад тохиромжтой хэрэгсэл биш юм. Эдгээрийг дан ганц цуглааныг тараахын тулд хэзээ ч ашиглах ёсгүй. Олон улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд цуглааны хүрээнд галт зэвсгийн аливаа хэрэглээг шууд амь насанд хүрэх, эсхүл ноцтой гэмтэл учруулах айсуу аюул заналхийллийг шийдвэрлэхэд нэн чухал нөхцөл байдалд тодорхой хувь хүмүүсээр хязгаарлагдах ёстой. Ийм зэвсэг амь насанд аюул заналхийлж байгааг харгалзан үзээд, энэхүү хамгийн доод хязгаарыг резинэн бүрээстэй төмөр сумаар буудахад бас хамаатуулах нь зүйтэй. Хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүч хэрэглэхэд бэлтгэгдсэн, эсхүл хүчирхийлэл үйлдэгдэх магадлалтай гэж үзвэл эрх баригчид мөн эмнэлгийн байгууллагууд нь хангалттай эсэхэд баталгаа өгөх ёстой. Цуглааны хэв журам сахиулж байх үеэр ялгаварлалгүйгээр хавтгайруулан гал нээх, эсхүл бүрэн автомат горимд галт зэвсэг хэрэглэх нь ямагт хууль бус юм.

89. Төр нь, олон улсын хууль тогтоомжийн дагуу хууль сахиулах байгууллагуудынхаа үйл ажиллагаа болон алдаануудад хариуцлага хүлээнэ. Зөрчлийг урьдчилан сэргийлэх зорилгоор, улсууд нь цуглааны үеэр хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудад хариуцлага хүлээлгэх соёлыг байнга сурталчлах нь зүйтэй. Үр дүнтэй хариуцлагыг дээшлүүлэхийн тулд, дүрэмт хувцастай хууль сахиулагчид цуглааны үеэр хялбар танигдахуйц таних хэлбэрийг байнга харуулж байх нь зүйтэй.

90. Улс орнууд, цуглааны хүрээнд, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хууль бусаар хүч хэрэглэсэн болон бусад зөрчлүүд, түүний дотор бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг аливаа мэдүүлэг, үндэслэлтэй сэжиглэлийг үр дүнтэй, алагчлалгүй, цаг хугацаанд нь шалгах үүрэгтэй. Санаатай болон хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэхүйн аль алиныг хүний эрхийн зөрчилд хамааруулж болно. Зөрчилд хамаатай хувь албан ажилтнууд дотоодын, мөн, холбогдох тохиолдолд, олон улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ёстой бөгөөд хохирогчдод тохирсон үр дүнтэй арга хэмжээг авах ёстой.

91. Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын хэрэглэсэн бүх хүчийг баримтжуулж, бичиж, ил тод тайланд цаг тухайд нь тусгасан байх ёстой. Осол гэмтэл, эсхүл хор хохирол учруулсан тохиолдолд, тэр тайлан нь хэрэглэсэн шалтгаан, түүний үр нөлөө, үр дагаврыг багтаасан үйл явдлын нарийн ширийн зүйлийг тодорхойлж, хүч хэрэглэх нь зайлшгүй, зохистой байсан эсэхийг нотлох хангалттай мэдээлэл агуулсан байх ёстой.

92. Жирийн хувцастай офицеруудыг цуглаанд байрлуулах нь тухайн нөхцөл байдалд зайлшгүй шаардлагатай байх ёстой бөгөөд ийм офицерууд хэзээ ч хүчирхийлэл өдөөх ёсгүй. Жирийн хувцасласан офицерууд нь нэгжлэг хийх, баривчлах, хүч хэрэглэхээс өмнө өөрсдийгөө холбогдох хүмүүст танилцуулах ёстой.

93. Төр нь цуглааны үеэр хууль сахиулах ажлыг хариуцах бөгөөд хувийн онцгой байдлын үйлчилгээ үзүүлэгчдэд зөвхөн онцгой тохиолдолд л даалгавар өгч болно. Ийм тохиолдолд, төр нь тэдгээр үйлчилгээ үзүүлэгчдийн үйлдэлд хариуцлага хүлээх нь хэвээрээ байна. Энэ нь хувийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дотоодын болон, холбогдох нөхцөлд, олон улсын хууль тогтоомжийн дагуу хүлээх хариуцлага дээр нэмэгдэнэ. Эрх баригчид, үндэсний аюулгүй байдлыг хангахад хувийн аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэгчдийн үүрэг, эрх мэдлийг үндэсний хууль тогтоомжид тусгаж, хүч хэрэглэх, сургах үйл ажиллагааг хатуу зохицуулах ёстой.

94. Цуглааны үеэр хууль сахиулах байгууллагын ажилтнууд бичлэг хийх төхөөрөмж, түүний дотор биед зүүдэг камерыг зүй зохистой ашиглах нь хариуцлага хүлээхэд эерэг үүрэг гүйцэтгэж болох юм. Гэсэн хэдий ч, эрх баригчид буюу эрх бүхий байгууллагууд нь, тоног төхөөрөмжийг ашиглах нь нууцлалтай холбоотой олон улсын хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх, цуглаанд оролцогчдод хор хохирол учруулахгүй байх үүднээс тодорхой, олон ийтэд нээлттэй удирдамжтай байх нь зүйтэй. Түүнчлэн, оролцогчид, сэтгүүлчид болон хянагчид хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг бичлэгт буулгах эрхтэй.

95. Төр нь жагсаалын үеэр ашиглаж буй алсын удирдлагатай аливаа зэвсгийн системийг бүрэн хариуцна. Хүчээ харуулах буюу үзүүлэх эдгээр аргууд нь хурцадмал байдлыг улам даамжруулж болзошгүй тэл зөвхөн маш болгоомжтой хэрэглэх нь зүйтэй. Системийг байрлуулсны дараагаар, хүний утга учиртай хөндлөнгийн оролцоогүйгээр, цуглаанд оролцогчдын эсрэг үхлийн хүчийг ашиглаж болох бүрэн бие даасан зэвсгийн системийг уг цуглааны үеэр хэзээ ч хууль сахиулахад ашиглаж болохгүй.

VII. Онцгой байдал, зэвсэгт мөргөлдөөний үеийн цуглаан

96. Тайван хуран цуглах эрх нь Пактын 4 дүгээр хэсгийн 2 дугаар зүйлд үл тоомсорлох эрхийн жагсаалтад ороогүй ч, хуран цуглахтай хамааралтай байж болох бусад эрхүүдийг, тухайлбал, 6, 7, 18 дугаар зүйлд заагдсан, үл хайхрахгүй байх. Хэрэв 21 дүгээр зүйлийн тухайд хязгаарлалт тавьж, өөрсдийн зорилгодоо хүрч чадвал оролцогч улсууд тайван жагсаал хийх эрхийг үл хайхрахыг урьтал болгох ёсгүй. Хэрэв хүчирхийллийн үйл ажиллагааг өөртөө агуулсан олон нийтийн жагсаалын хариуд улс орнууд Пактаас татгалзаж байгаа бол, тэд улс үндэстний амьдралд аюул заналхийлж буй тийм нөхцөл байдал төдийгүй Пактын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаас татгалзуулсан бүх арга хэмжээнүүд нь тухайн нөхцөл байдлын хэрэгцээ шаардлагаар чанд хатуу шаардагдсан ба 4 дүгээр зүйлд заасан нөхцлүүдийг дагаж мөрдөж байгааг нотлох чадвартай байх ёстой.

97. Зэвсэгт мөргөлдөөний үеийн тайван цуглааны үеэр хүч хэрэглэх нь хууль сахиулах үйл ажиллагааны зохицуулах дүрмээр зохицуулагддаг болон Пактыг мөрдсөн хэвээр буй. Байлдааны ажиллагаанд шууд оролцоогүй бол, цуглаанд оролцож буй энгийн иргэд үхлийн хүчний бай болохоос хамгаалдаг бөгөөд энэхүү нэр томьёо нь мөн олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хүрээнд ойлгогддог. Ийм нөхцөлд, зөвхөн олон улсын хууль тогтоомжийн дагуу халдлагаас хамгаалагдаагүй тохиолдолд л тэднийг онилж болох юм. Олон улсын хүмүүнлэгийн холбогдох хууль тогтоомжийн дагуу аливаа хүч хэрэглэх нь онцлон ялгах дүрэм ба зарчмууд, дайралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зүй зохистой байдал, цэргийн чухал шаардлага болон хүнлэг байдлаас шалтгаална. Хүч хэрэглэх тухай бүх шийдвэрийн хүрээнд, цуглаанд оролцогчдын болоод олон нийтийн аюулгүй байдал, хамгаалалтыг чухалчлан авч үзэх нь зүйтэй.

VIII. 21 дүгээр зүйл болон Пактын болоод бусад хууль эрх зүйн дүрэм журмуудын хоорондох харилцаа хамаарал

98. Тайван хуран цуглах эрхийг бүрэн хамгаалах нь олон төрлийн эрхийг хамгаалахаас шалтгаалдаг. Цуглааны үеэр төрийн албан тушаалтнууд шаардлагагүй, эсхүл зүй зохисгүйгээр хүч хэрэглэх болон бусад хууль бус үйлдлийг хийх нь Пактын 6, 7, 9 дүгээр зүйлүүдийг зөрчиж болзошгүй. Цуглаанд оролцоходоо аливаа энгийн эргэний эсрэг чиглэгдсэн өргөн хүрээний, эсхүл систем бүхий халдлагын нэг хэсэг болсон үйлдэл, эсхүл хууль бусаар хүч хэрэглэсэнд буруутгагдаж буй оролцогдын гэх мэт маш онцгой нөхцөл, бусад холбогдох шаардлагуудыг хангасан бол, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт мөн хамаарна.

99. Цуглаан, жагсаал болон бусад хөдөлгөөн цуглаанд оролцох зорилгоор аялах, үүн дотор гадаадад зорчих (12 дугаар зүйлийн 2) гэх мэт оролцогчдын хөдөлгөөний эрх чөлөөг хязгаарлах нь тэдний эрх чөлөөг зөрчиж болох юм (12 дугаар зүйлийн 1). Цуглааны эрхийг хязгаарлах тухай албан ёсны шийдвэрүүд нь шударга, олон нийтийн сонсголын шаардлагыг хангасан үйл явц бүхий хууль ёсны сорилтод ороход нээлттэй байх ёстой (14 дүгээр зүйлийн 1). Цуглаан болон бусад мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд оролцсон хүмүүсийг хянах нь тэдний хувийн нууцыг хамгаалах эрхийг зөрчиж болзошгүй (17 дугаар зүйл). Шашны цуглааныг шашин шүтлэг, итгэл үнэмшлээ илэрхийлэх эрх чөлөөгөөр хамгаалуулж болно (18 дугаар зүйл). Тайван хуран цуглах эрх нь дан ганц үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний илрэл биш (19 дүгээр зүйлийн 2). Энэ нь ихэвчлэн илэрхийлэх элементтэй байдаг бөгөөд эдгээр хоёр эрхийг хүлээн зөвшөөрөх үндэслэл ба хүлээн зөвшөөрөгдсөн хязгаарлалтууд нь олон талаар давхцдаг. Төрийн байгууллагуудын эзэмшиж буй мэдээлэлд нэвтрэх эрх чөлөө (19 дүгээр зүйлийн 2) нь олон нийтийн цуглаанд хамаарах хууль эрхзүйн болон захиргааны хүрээний талаар мэдэх үндэс суурь болдог бөгөөд энэ нь төрийн албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх боломжийг олгодог.

100. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө (22 дугаар зүйл) нь мөн хамтын үйлдлийг хамгаалдаг бөгөөд энэ эрхийг хязгаарлах нь тайван замаар хуран цуглах эрхэд ихэнхдээ нөлөөлдөг. Улс төрийн оролцооны эрх нь (25 дугаар зүйл) нь тайван цуглах эрхтэй нягт холбоотой бөгөөд тодорхой холбогдох нөхцлүүдэд, хязгаарлалт нь 21 болон 25 дугаар зүйлд тусгасан шаардлагуудын дагуу байх ёстой. Үл ялгаварлан гадуурхагдах эрх нь оролцогчдыг цуглааны нөхцөл байдалд ялгаварлан гадуурхах явдлын эсрэг хамгаалдаг (2 дугаар хэсгийн 1 болон 24, 26 дугаар зүйлүүд).

101. Бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс 21 дүгээр зүйлд заасны дагуу тайван цуглаанд оролцоход хориг тавьж болно.

102. Тайван хуран цуглах эрх нь өөрийн гэсэн салшгүй үнэ цэнтэй. Түүнчлэн, уг эрхийг ихэвчлэн хүний бусад эрх, олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээ, зарчмуудын хэрэгжилтийг ахисан түвшинд гаргах зорилгоор хэрэгжүүлдэг. Ийм тохиолдолд, тайван хуран цуглах эрхийг хүндэтгэх, хангах үүргийн хууль зүйн үндэслэл нь уг эрхийн бусад өргөн хүрээний эрх, хэм хэмжээ, зарчмуудын хэрэгжилтийг сайжруулах ач холбогдол дээр тулгуурлана.